



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 057

Улаанбаатар хот

"Гетженероус" ХХК-ийн гомдлын тухай

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Д.Сайханчулуун даргалж, гишүүд Х.Төмөрбаатар, Ё.Наранбилэг, Х.Нямбаяр, Б.Төгслхам, Ц.Алтанцэцэг, Д.Мөнхтуул, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, "Гетженероус" ХХК-аас Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 0299555 дугаар шийтгэлийн хуудсанд гаргасан гомдлыг, тус компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Бямбасүх, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Т.Сайнжаргал, Т.Батсүх нарыг оролцуулан магадлагч-татварын улсын байцаагч Г.Ганбат магадалгаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. "Гетженероус" ХХК-ийн захирал Х.Гантөмөр нь Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо: "Гетженероус ХХК нь 2008 онд цахилгаан хөдөлгүүрийн засвар, үйлчилгээ эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдаж, одоог хүртэл Баянгол дүүргийн Татварын хэлтэст харьяалалтай үйл ажиллагаа явуулж байна.

Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч нар удирдлагын шийдвэрээр шалгалт хийж, 68,877,182.60 төгрөгийн татвар, 20,663,182.60 төгрөгийн торгууль, 16,885,939.80 төгрөгийн алданги нийт 106,426,277.20 төгрөгийн төлбөр бүхий шийтгэлийн хуудас бичсэн.

Тухайн шийтгэлийн хуудсыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэн хүлээн зөвшөөрөөгүй болно. Татварын ерөнхий хуульд заасны дагуу Маргаан таслах зөвлөлд хандаж байна." гэж тэмдэглэсэн,

2. Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Батсүх, Т.Сайнжаргал нар ирүүлсэн тайлбартаа: "Тус татварын хэлтэст бүртгэлтэй, 5268478 регистрийн дугаартай, цахилгаан хөдөлгүүр угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "Гетженероус" ХХК-ийн 2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдөр дуусталх хугацааны нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг "Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж", Татварын ерөнхий газрын 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 07/778 тоот албан тоот, Татварын хяналт шалгалтын тасгийн даргын олгосон 26180400198 томилолтын дагуу хэсэгчилсэн шалгалт хийсэн.

Тус компанийн 2016 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийх явцад 1,961,550,143.65 төгрөгийн борлуулалтын орлоготой, 1,620,964,905.37 төгрөгийн худалдан авалттай, 35,871,648.0 төгрөгийн ногдолтой тайланг татварын албанд цахим хэлбэрээр ирүүлж баталгаажуулсан байна. Энэ татварын төрлөөр төсөвт 14,657,043.70 төгрөг төлсөн байна.

Борлуулалтын орлогын хувьд 2016 оны нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаар 24 ширхэг падаанаар нийт 1,961,550,143.65 төгрөгийн борлуулалтын орлогоос 2076675 регистрийн дугаартай "Улаанбаатар төмөр зам" ХНН-ий 1,736,775,930.00 төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Худалдан авалтын хувьд 2016 онд 5608678 регистрийн дугаартай "Тансаг өндөр констракшн" ХХК-аас бараа материал худалдан авах 1,485,649,000.00 төгрөгийн /нэмэгдсэн өртгийн албан татваргүй дүн 1,350,590,000.00 төгрөг/ гэрээ хийж, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд худалдан авалтаар хасалт хийж, тайлагнасан байна. Төлбөрийн хувьд тус компани нь "Тансаг өндөр констракшн" ХХК-ийн харилцах дансанд 2016 онд 64,000,000.00 төгрөг, 2017 онд 664,000,000.00 төгрөг нийт 728,000,000.00 төгрөгийн төлөлтийг харилцах дансаар хийсэн байна.

"Гетженероус" ХХК-ийн 2016 оны нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч Ц.Батсүх, Т.Сайнжаргал нар шалгалт хийж, 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр "Тансаг өндөр констракшн" ХХК-тай холбоотой 688,771,825.97 төгрөгийн зөрчилд татварын улсын байцаагчийн 260000397 тоот дүгнэлт бичсэн байна.

"Гетженероус" ХХК нь 2016 онд 5608678 регистрийн дугаартай "Тансаг өндөр констракшн" ХХК-аас бараа материал худалдан авах 1,485,649,000.00 төгрөгийн /нэмэгдсэн өртгийн албан татваргүй дүн 1,350,590,000.00 төгрөг/ гэрээ хийж, 2016 оны 03 сард 96,000,000.00 төгрөг, 2016 оны 04 сард 355,909,090.90 төгрөг, 2016 оны 05 сард 92,136,363.63, 60 төгрөг, 2016 оны 06 сард 245,863,636.36 төгрөг, 2016 оны 07 сард 90,909,090.91 төгрөг, 2016 оны 08 сард 231,781,818.18 төгрөг, 2016 оны 10 сард 90,720,000.00 төгрөг, 2016 оны 11 сард 147,270,000.00 төгрөг нийт 1,350,590,000.00 төгрөгийн худалдан авалтыг нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд худалдан авалтаар хасалт хийж, тайлагнасан байна. Үүнээс 2016 онд "Тансаг өндөр констракшн" ХХК-ийн харилцах дансанд 64,000,000.00 төгрөг, 2017 онд 664,000,000.00 төгрөг нийт 728,000,000.00 төгрөгийн төлөлтийг харилцах дансаар хийсэн байна. Кассаар /бэлэн мөнгө/ төлсөн гэх 757,649,000.00 төгрөгийн худалдан авалтыг эрсдэлтэй гэж үзэн дүгнэлт бичигдсэн.

Тус компанийн 2016 оны нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд "Тансаг өндөр констракшн" ХХК-аас 688,771,825.97 төгрөгийн хуурамч бичилт бүхий нэмэгдсэн өртгийн албан татварын падаанаар бараа материал худалдан авалт хийсэн байна. Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Татварын улсын байцаагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 29.1.1. татвар ногдуулах, төлөх татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, төсөл болон санхүүгийн бусад баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулан авах, зөрчлийг тогтоон акт, дүгнэлт, холбогдох бусад баримт үйлдэх, 29.1.6. татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид энэ хуулийн 74.1, 74.2, 74.3 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх" гэж заасныг үндэслэн акт үйлдсэн болно.

"Гетженероус" ХХК нь татварын улсын байцаагчийн 260299555 тоот актын төлбөрийг үл зөвшөөрч Нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд гомдлоо гаргасан байна." гэж тэмдэглэсэн

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадалгаа хийж, татварын улсын байцаагчийн 0299555 тоот шийтгэлийн хуудсаар 68,877,182.60 төгрөгийн татвар, 20,663,182.60 төгрөгийн торгууль, 16,885,939.80

төгрөгийн алданги нийт 106,426,277.20 төгрөгийн төлбөр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэснийг Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хүрээнд зөв тайлагнасан үндэслэлээр бүхэлд нь хүчингүй болгох гэсэн саналыг оруулсан.

ҮНДЭСЛЭХ НЬ:

"Гетженероус" компанийн 2016 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Т.Сайнжаргал, Ц.Батсүх нар Татварын ерөнхий газрын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 0299555 тоот шийтгэлийн хуудсаар 688,771,825.9 төгрөгийн зөрчил илрүүлж, 68,877,182.6 төгрөгийн нөхөн татвар, 20,633,154.8 төгрөгийн торгууль, 16,885,939.8 төгрөгийн алданги нийт 106,426,277.2 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшөөрч гомдол гаргажээ.

"Гетженероус" ХХК нь 5608678 тоот регистрийн дугаартай "Тансаг өндөр констракшн" ХХК-аас 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 0022384994 тоот падаанаар 96,000,000.0 төгрөгийн, 4 дүгээр сарын 30-ны өдрийн 0023044524 тоот падаанаар 355,909,090.9 төгрөгийн, 5 дугаар сарын 31-ний өдрийн 0024228510 тоот падаанаар 92,136,363.6 төгрөгийн, 6 дугаар сарын 30-ны өдрийн 00107623906 тоот падаанаар 245,863,636.3 төгрөгийн, 7 дугаар сарын 31-ний өдрийн 00284858387 тоот падаанаар 90,909,090.9 төгрөгийн, 8 дугаар сарын 3-ний өдрийн 435509893 тоот падаанаар 231,781,818.1 төгрөгийн, 10 дугаар сарын 31-ний өдрийн 803300082 тоот падаанаар 90,720,000.0 төгрөгийн, 11 дүгээр сарын 30-ны өдрийн 983692714 тоот падаанаар 147,270,000.0 төгрөгийн нийт 1,350,590,000.0 төгрөгийн худалдан авалт хийж, нэмэгдсэн өртгийн албан татварын 2016 оны 3,4,5,6,7,8,10,11 дүгээр сарын тайланд тусгасан нь татварын албаны /e-tax.mta.mn/local/login/ программаас нотлогдож байна.

Тус компани нь худалдан авалтын төлбөрийг "Тансаг өндөр констракшн" ХХК-ийн 370100014638 тоот харилцах дансанд 2016 онд 64,000,000.00 төгрөг, 2017 онд 664,000,000.00 төгрөг нийт 728,000,000.00 төгрөгийн гүйлгээ хийсэн нь дансны хуулгаар нотлогдож байна.

"Тансаг өндөр констракшн" ХХК нь хий бичилттэй падаан тараадаг болохыг хууль хяналтын байгууллагаас нотолж, Татварын ерөнхий газарт 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас 10-3/827 тоот албан бичгийг ирүүлсэн.

"Гетженероус" ХХК нь 2016 онд 688,771,826.0 төгрөгийн хий бичилттэй худалдан авалт хийж, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулсан зөрчил нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дах заалтыг зөрчсөн гэж тэмдэглээд Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дах заалтыг үндэслэн ногдуулсан 68,877,182.6 төгрөгийн нөхөн татвар, 20,663,182.6 төгрөгийн торгууль, 16,885,939.8 төгрөгийн алданги нийт 106,426,277.2 төгрөгийн төлбөрийг хэвээр үлдээх зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.


Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дах заалтуудыг үндэслэн татварын улсын байцаагчийн 0299555 тоот шийтгэлийн хуудсаар 688,771,826.0 төгрөгийн зөрчил илрүүлж, 68,877,182.6 төгрөгийн нөхөн татвар, 20,663,182.6 төгрөгийн торгууль, 16,885,939.8 төгрөгийн алданги нийт 106,426,277.2 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээсүгэй.

2. Шийдвэрийг эс зөвшөөрвөл шийтгэлийн хуудсанд гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ХУРАЛ ДАРГАЛСАН:



Д.САЙХАНЧУЛУУН

ГИШҮҮД :



Ц.АЛТАНЦЭЦЭГ




Х.ТӨМӨРБААТАР




Ё.НАРАНБИЛЭГ



Х.НЯМБАЯР



Д.МӨНХТУУЛ



Б.ТӨГСЛХАМ



Ж.ЭРДЭНЭБҮРЭН